



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/156

Хужирт сум


Залуучуудын хөгжлийн зөвлөл
байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” А/72 дугаар тушаалын 5.1.6, 5.2.1, 5.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуучуудын үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, хөгжил оролцоо, санал санаачлагыг дэмжих, тэдгээрийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий сумын залуучуудын хөгжлийн зөвлөлийг хавсралтаар байгуулсугай.

2. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг “Залуучуудын хөгжлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн хүрээнд зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллахыг Залуучуудын хөгжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2021 оны 11 дугаар
сарын 01-ны өдрийн 1118 дугаар
захирамжийн хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар зөвлөлийн дарга: Сумын Засаг дарга

Салбар зөвлөлийн дэд дарга: 4 дүгээр багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд :

Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан

Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан

Мал эмнэлэгийн тасгийн Тархвар зүйч

Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш

Ерөнхий боловсролын сургуулийн дуу хөгжмийн багш

Өвөрмодот 1 дүгээр багийн Засаг дарга

Уужим 2 дугаар багийн Засаг дарга

Бэрх 3 дугаар багийн Засаг дарга

Шивээт 4 дүгээр багийн Засаг дарга

Дулаан 6 дугаар багийн Засаг дарга

Оюутан залуусын төлөөлөл: Д.Баттүвшин

Малчин залуусын төлөөлөл: Д.Сэр-Од

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл: О.Бямбатогтох